



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын Г  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол овоо ХХК "Прогресс" зочид буудлын 16/008, Шангри-Ла Улаанбаатар хотел ХХК "Шангри-ла улаанбаатар хотел" зочид буудлын 15/040, Хүннү ХХК "Хүннү палас" зочид буудлын 14/022, Колумбас ХХК "Болор" дэн буудлын 14/007, Жингийн халзан ХХК "Харз-2" дэн буудлын 13/274, Иргэн Р.Соёл-эрдэнэ "Алтан тэвш" дэн буудлын 16/005, Иргэн Г.Солонго 15/010 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.
4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.
5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

1150500114

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batsoo* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 04 сарын 04-ний өдрийн А/30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.04.04

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монгол угсаа ХХК	6116914	Юу би Сүйтэс хотел	БЗД-ийн 2-р хороо Б.Доржийн гудамж
2	Хүннү ХХК	2084538	Хүннү палас	СБД-ийн 11-р хороо Их тойруу 13
3	Шангри-Ла Улаанбаатар хотел ХХК	5149037	Шангри-Ла Улаанбаатар хотел	СБД-ийн 1-р хороо олимпийн гудамж 19
4	Монгол овоо ХХК	2801418	Прогресс	БГД-ийн 5-р хороо Энхтайваны өргөн чөлөө 58

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 04 сарын 04-  
ний өдрийн А/30 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.04.04

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Колумбас ХХК	2713004	Болор	БГД-ийн 11-р хороо Өргөө гудамж 28
2	Мега тур ХХК	5785251	Сара	ЧД-ийн 4-р хороо 19а-13
3	Иргэн Г.Солонго	ЦЖ77071461		БГД-ийн 13-р хороо 8-р байрны өргөтгөл
4	Иргэн Р.Соёл-эрдэнэ	ЧП69073103	Алтан тэвш	БГД-ийн 22-р хороо 18-135
5	Жингийн халзан ХХК	2724464	Харз-2	СХД-ийн 10-р хороо Зүүнбаян уулын 7-3

-ooOoo-